

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/247/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитор: Г.Мөнхбаяр

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.6.1 Төсвийн төлөвлөлт	13
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.6.3 Нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЦУОШГ	Цаг уур орчны шинжилгээний газар
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс
БҮТЭЗ	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.24 № 01/199
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УС, ЦАГ УУР,
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА Г.АДЪЯАСҮРЭН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>163,577,300.26</u>	<u>184,692,422.39</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	163,577,300.26	184,692,422.39
351	Түүхий эд материал	142,602,651.29	163,875,299.39
35110	Тусгай зориулалттай материал	142,602,651.29	163,875,299.39
354	Хангамжийн материал	13,919,648.97	14,722,123.00
35410	Бичиг хэргийн материал	930,300.00	1,134,000.00
35420	Аж ахуйн материал	3,181,000.00	4,571,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	479,600.00	479,600.00
35440	Түлш, шатах тослох материал	3,087,825.97	1,635,000.00
35450	Барилгын засварын материал	1,551,400.00	400,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,689,523.00	6,502,523.00
35600	Мал амьтад	7,055,000.00	6,095,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,170,123,043.57	1,305,235,473.66
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,170,123,043.57	1,305,235,473.66
392	Биет хөрөнгө	233,188,843.57	367,783,218.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	144,928,120.00	159,928,120.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-29,848,948.48	-35,080,972.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	76,867,573.78	64,767,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	-26,914,940.62	-22,797,036.21
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	687,168,489.19	222,736,315.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-647,291,248.52	-47,253,040.89
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,298,035.00	11,972,260.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,534,097.74	-6,912,632.08
39214	Бусад үндсэн хөрөнгө	73,986,651.50	73,986,651.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-48,470,790.54	-53,564,020.38
393	Биет бус хөрөнгө	936,934,200.00	937,452,255.56
39301	Програм хангамж	00.00	525,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-6,944.44
39303	Бусад биет бус хөрөнгө	936,934,200.00	936,934,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,333,700,343.83	1,489,927,896.05
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,333,700,343.83	1,489,927,896.05
51	Засгийн газрын хувь оролцоо	1,333,700,343.83	1,489,927,896.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		1,579,951,109.30	1,579,951,109.30
51101	Өмч: - төрийн	1,579,951,109.30	1,579,951,109.30
512	Хуримтлагдсан үр дүн	-341,399,520.47	-185,012,408.25
51210	Өмнөх үеийн үр дүн	-341,399,520.47	-341,239,960.47
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	156,227,552.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	95,148,755.00	94,989,195.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,333,700,343.83	1,489,927,896.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,185,733,841.66	2,265,571,879.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	304,998,390.66	352,437,763.05
120	Нийтлэг татварын бус орлого	304,998,390.66	352,437,763.05
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	304,998,390.66	352,437,763.05
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,355,600.00	1,304,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	303,642,790.66	351,133,663.05
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,880,735,451.00	1,913,134,116.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,817,724,100.00	1,824,977,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,817,724,100.00	1,824,977,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,011,351.00	88,156,716.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	57,841,191.00	67,798,176.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,170,160.00	17,346,940.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,011,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,078,754,691.21	2,109,344,326.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,078,754,691.21	2,109,344,326.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,955,344,139.82	1,997,261,156.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,441,710,882.00	1,454,704,279.00
210101	Үндсэн цалин	992,502,917.00	980,843,300.00
210102	Нэмэгдэл	408,536,961.00	429,481,894.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,671,004.00	44,379,085.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	184,153,416.77	189,821,635.00
210201	Тэтгэврийн даатгал	126,762,820.77	132,574,097.47
210202	Тэтгэмжийн даатгал	14,195,477.00	14,533,893.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,641,670.00	11,505,734.54
210204	Ажилгүйдлийн даатгал	2,868,497.00	2,837,026.69
210205	Эрүүл мэндийн даатгал	28,684,952.00	28,370,883.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,584,272.84	44,126,056.00
210301	Гэрэл, цахилгаан	23,586,073.01	32,799,500.00
210302	Түлш, халаалт	10,998,199.83	11,326,556.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,175,027.00	15,573,722.97
210401	Бичиг хэрэг	2,177,790.00	2,250,450.00
210402	Тээвэр, шатахуун	8,104,250.00	6,087,475.97
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,130,377.00	2,499,220.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,762,610.00	2,836,577.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	1,900,000.00
2105	Нормативт зардал	2,788,591.00	3,327,850.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,334,100.00	1,734,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,454,491.00	1,593,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,943,680.00	6,185,240.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	857,500.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	610,000.00	85,500.00
210604	Урсгал засвар	4,476,180.00	6,099,740.00
2107	Томилолт, зочны зардал	8,474,000.00	2,688,000.00
210702	Дотоод албан томилолт	8,474,000.00	2,688,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	214,513,502.19	64,778,878.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	210,197,132.19	55,562,254.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	600,000.00

**Хөвсгөл аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210803	Даатгалын үйлчилгээ	133,950.00	381,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,000.00	94,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	66,000.00
210807	Газрын төлбөр	4,084,420.00	8,074,824.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,000,768.02	216,055,495.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,657,000.00	175,274,572.25
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	209,400.00	420,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,134,368.02	40,360,223.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	123,410,551.39	112,083,170.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	95,350,900.00	101,109,065.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	95,170,900.00	101,109,065.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	180,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,059,651.39	10,974,105.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,059,651.39	10,974,105.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	106,979,150.45	156,227,552.22
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	77,681,948.85	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	77,681,948.85	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-77,681,948.85	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	106,979,150.45	156,227,552.22

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

				<i>/төгрөг/</i>
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,579,951,109.30	-458,103,233.72	1,226,721,193.38
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	9,724,562.80	9,724,562.80
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,579,951,109.30	-448,378,670.92	1,236,445,756.18
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	106,979,150.45	106,979,150.45
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,579,951,109.30	-341,399,520.47	1,333,700,343.83
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,579,951,109.30	-341,399,520.47	1,333,700,343.83
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	159,560.00	159,560.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,579,951,109.30	-341,239,960.47	1,333,859,903.83
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	-159,560.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	156,227,552.22	156,227,552.22
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,579,951,109.30	-185,012,408.25	1,489,927,896.05

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

				<i>/төгрөг/</i>
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,882,091,051.00	1,914,438,216.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,355,600.00	1,304,100.00	
120	Нийтлэг татварын бус орлого	1,355,600.00	1,304,100.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,355,600.00	1,304,100.00	

Хөвсгөл аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,355,600.00	1,304,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,880,735,451.00	1,913,134,116.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,817,724,100.00	1,824,977,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,817,724,100.00	1,824,977,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,011,351.00	88,156,716.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	57,841,191.00	67,798,176.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,170,160.00	17,346,940.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,011,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,875,562,951.00	1,890,899,216.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,875,562,951.00	1,890,899,216.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,752,152,399.61	1,778,816,046.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,441,710,882.00	1,454,704,279.00
210101	Үндсэн цалин	992,502,917.00	980,843,300.00
210102	Нэмэгдэл	408,536,961.00	429,481,894.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,671,004.00	44,379,085.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	184,153,416.77	189,821,635.00
210201	Тэтгэврийн даатгал	126,762,820.77	132,574,097.47
210202	Тэтгэмжийн даатгал	14,195,477.00	14,533,893.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,641,670.00	11,505,734.54
210204	Ажилгүйдлийн даатгал	2,868,497.00	2,837,026.69
210205	Эрүүл мэндийн даатгал	28,684,952.00	28,370,883.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,667,964.84	42,148,756.00
210301	Гэрэл, цахилгаан	23,832,465.01	32,799,500.00
210302	Түлш, халаалт	11,835,499.83	9,349,256.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,988,177.00	15,163,897.00
210401	Бичиг хэрэг	2,672,090.00	2,039,150.00
210402	Тээвэр, шатахуун	9,101,750.00	6,611,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,130,377.00	3,049,220.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,083,960.00	3,463,577.00
2105	Нормативт зардал	4,350,791.00	4,829,850.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,440,600.00	1,734,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,910,191.00	3,095,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,287,680.00	5,476,840.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,630,100.00	443,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	630,000.00	85,500.00
210604	Урсгал засвар	6,027,580.00	4,948,340.00
2107	Томилолт, зочны зардал	8,889,600.00	2,688,000.00
210702	Дотоод албан томилолт	8,889,600.00	2,688,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,735,038.00	62,933,878.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,418,668.00	53,717,254.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	133,950.00	381,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,000.00	94,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	66,000.00
210807	Газрын төлбөр	4,084,420.00	8,074,824.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,368,850.00	1,048,911.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	948,450.00	628,211.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	420,400.00	420,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	123,410,551.39	112,083,170.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	95,350,900.00	101,109,065.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	95,170,900.00	101,109,065.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	180,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,059,651.39	10,974,105.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,059,651.39	10,974,105.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,528,100.00	23,539,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	23,539,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	23,539,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	23,539,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	23,539,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-23,539,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,825,977,400.0	1,815,307,395.0	10,670,005.0	99.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,825,977,400.0	1,815,307,395.0	10,670,005.0	99.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,722,081,000.0	1,714,198,330.0	7,882,670.0	99.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,455,810,500.0	1,454,704,279.0	1,106,221.0	99.9
210101	Үндсэн цалин	980,843,300.0	980,843,300.0	00.0	100.0
210102	Нэмэгдэл	430,343,000.0	429,481,894.0	861,106.0	99.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,624,200.0	44,379,085.0	245,115.0	99.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	196,534,400.0	189,821,635.0	6,712,765.0	96.6
210201	Тэтгэврийн даатгал	138,302,000.0	132,574,097.5	5,727,902.5	95.9
210202	Тэтгэмжийн даатгал	14,558,100.0	14,533,893.2	24,206.8	99.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,646,500.0	11,505,734.5	140,765.5	98.8
210204	Ажилгүйдлийн даатгал	2,911,600.0	2,837,026.7	74,573.3	97.4
210205	Эрүүл мэндийн даатгал	29,116,200.0	28,370,883.1	745,316.9	97.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,157,700.0	42,148,756.0	8,944.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	32,799,500.0	32,799,500.0	00.0	100.0
210302	Түлш, халаалт	9,358,200.0	9,349,256.0	8,944.0	99.9
2104	Хангамж, бараа материалын зардал	8,284,500.0	8,277,599.0	6,901.0	99.9
210401	Бичиг хэрэг	1,495,500.0	1,495,450.0	50.0	100.0

**Хөвсгөл аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210402	Тээвэр, шатахуун	3,061,200.0	3,056,629.0	4,571.0	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,499,900.0	2,499,220.0	680.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,227,900.0	1,226,300.0	1,600.0	99.9
2105	Нормативт зардал	1,512,700.0	1,512,650.0	50.0	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	845,100.0	845,050.0	50.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	667,600.0	667,600.0	00.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,371,500.0	1,371,500.0	00.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,286,000.0	1,286,000.0	00.0	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	85,500.0	85,500.0	00.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,218,000.0	2,178,000.0	40,000.0	98.2
210702	Дотоод албан томилолт	2,218,000.0	2,178,000.0	40,000.0	98.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,141,000.0	13,135,000.0	6,000.0	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,918,400.0	9,918,400.0	00.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.0	600,000.0	00.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	381,800.0	381,800.0	00.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.0	94,000.0	6,000.0	94.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.0	66,000.0	00.0	100.0
210807	Газрын төлбөр	2,074,800.0	2,074,800.0	00.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,050,700.0	1,048,911.0	1,789.0	99.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	630,000.0	628,211.0	1,789.0	99.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	420,700.0	420,700.0	00.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,896,400.0	101,109,065.0	2,787,335.0	97.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	103,896,400.0	101,109,065.0	2,787,335.0	97.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	103,896,400.0	101,109,065.0	2,787,335.0	97.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,825,977,400.0	1,815,307,395.0	10,670,005.0	99.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,824,977,400.0	1,814,003,295.0	10,974,105.0	99.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,824,977,400.0	1,814,003,295.0	10,974,105.0	99.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.0	1,304,100.0	-304,100.0	130.4
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.0	1,304,100.0	-304,100.0	130.4
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	122.00	122.00	00.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	113.00	113.00	00.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00	00.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	88,156,716.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	88,156,716.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,156,716.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,886,298.00
210401	Бичиг хэрэг	543,700.00
210402	Тээвэр, шатахуун	3,555,321.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	550,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,237,277.00
2105	Нормативт зардал	3,317,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	889,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,428,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,644,340.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,696,000.00
210604	Урсгал засвар	4,948,340.00
2107	Томилолт, зочны зардал	510,000.00
210702	Дотоод албан томилолт	510,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,798,878.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,798,854.00
210807	Газрын төлбөр	6,000,024.00
221001	Их засвар	15,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	88,156,716.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	88,156,716.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	67,798,176.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,346,940.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,011,600.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гүйцэтгэх захирал Т.Батсайхан, аудитор Г.Мөнхбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Төгс суурь стандарт аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар

хэрэгжүүлж аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Хөвсгөл аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Төгс суурь стандарт аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 19 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь 2021 онд аймаг, хот, нутаг дэвсгэрийн хэмжээнд ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлыг батлагдсан хөтөлбөр, заавар, журмын дагуу гүйцэтгэх, мэдээллээр төр, захиргаа, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг хангах зорилго тавьж ажилласан байна.

Хөвсгөл аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ус цаг уур орчны шинжилгээний талаар судалгаа мэдээлэл хийх
- Хөрсний дээжийн шинжилгээ хийх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.
- Засгийн газрын 2021 оны 43 тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэх тухай” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,163.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 17.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,109.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 31.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 25.3 сая төгрөгөөр тогтоосон нь суурь үзүүлэлтийн дүн өөрчлөгдсөнтэй холбоотой.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 156.2 сая төгрөгөөр буюу 11.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая.төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	163.6	184.7	21.1
Үндсэн хөрөнгө	1170.1	1305.2	135.1
Биет бус хөрөнгө	936.9	937.5	0.5
Нийт хөрөнгө	1333.7	1489.9	156.2
Эздийн өмч	1580.0	1580.0	0.0
-төрийн	1580.0	1580.0	0.0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	95.1	95.0	-0.2
Хуримтлагдсан үр дүн	-341.4	-185.0	156.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1333.7	1489.9	156.2

Тайлант онд мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөрийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 184.7 сая төгрөг болж өмнөх оноос 21.1 сая төгрөгөөр өссөн нь УЦОШГ-аас 196.0 сая төгрөгийн тусгай зориулалтын материал, 8.2 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж шилжүүлэн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,305.2 сая төгрөг болж 135.1 сая төгрөгөөр өссөн нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 220 тогтоолоор, ЦУОШГ-ын даргын 2021 оны А/95 тоот тушаалаар 266.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 508 дугаар тогтоолоор 371.7 сая төгрөгийн үлдэх өртөггүй үндсэн хөрөнгө болох тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийг 144.6 сая төгрөгөөр үнэлж орлого болгосонтой холбоотой байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 937.5 сая төгрөг болж 0.5 сая төгрөгөөр өссөн нь:

- Санхүүгийн программ үнэлж авсан 0.25 сая төгрөг /ТӨБЗГ-ын 2021 оны №508 тоот тогтоолоор/
- Няравын программ 0.3 сая төгрөг /Санхүүгийн тооцоолох групп” ХХК-тай байгуулсан 2021 оны 09 тоот гэрээ /ЦУОШГ-ын даргын 2021 оны А/233 тушаалаар/

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл тайлант хугацаанд -185.0 сая төгрөг болж 156.4 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 108.3 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 13.0 сая төгрөг,

ажил олгогчоос төлөх НДШ 5.7 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 9.5 сая төгрөг, хангамжийн материалын зардал 0.4 сая төгрөг, норматив зардал 0.5 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 0.3 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 168.0 сая төгрөгөөр өсөж, томилолтын зардал 5.8 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 72.0 сая төгрөг, урсгал шилжүүлэг 11.3 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд дээд шатны төсвийн захирагчид 1,877.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн байгууллагад 2021 оны төсөвт 47.7 сая төгрөгөөр бууруулж 1,825.3 сая төгрөгөөр баталж, 2021 оны 12 сарын 17-ны өдрийн тодотгосон төсвөөр нийт санхүүжилт 1,826.0 сая төгрөг болж 3.3 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,826.0 сая төгрөгийн төсөв батлагдсан. Үүнд:

- Урсгал санхүүжилт 1712.2 сая төгрөг,
- Өөрийн орлогоос 1.0 сая төгрөг,
- Суваг мэдээний зардал 8.9,
- Нэг удаагийн тэтгэмж 103.9 сая төгрөг.

Гүйцэтгэлээр нийт 1,826.0 сая төгрөгийн санхүүжилт буюу 100%-ийн санхүүжилтийг авч, нийт 4.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,815.0 сая төгрөгийг зарцуулж мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө 11.0 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь:

- БНСУ-ын КОМПСАТ хиймэл дагуулын дүрс мэдээний заслага /баталгаажилтын төслийн/ Хөвсгөл аймаг дахь талбайн 2020 оны гэрээний 3 дахь санхүүжилт болох 6.3 сая төгрөг, 2021 оны гэрээний 2 үе шатны санхүүжилт болох 61.5 сая төгрөг,
- ЦУОШГ-ын даргын тушаал 2021 оны А/47 тоот тушаалаар Мэдээлэл дамжуулах гэр интернэт, сим карт худалдан авах зориулалтад 0.6 сая төгрөг,
- ЦУОШГ-ын даргын тушаал 2021 оны А/59 тоот тушаалаар Хөлсний үржил шим бохирдол цөлжилтийн судалгааны 1500 цэгээс сорьц авах зориулалтаар 1.8 сая төгрөг,
- ЦУОШГ-ын даргын тушаал 2021 оны А/146 тоот тушаалаар хөрөнгийн зардал гаргах зориулалтаар 15.0 сая төгрөг,
- Сангийн сайдын 2021 оны 217 тоот тушаалаар улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрх олгох зориулалтаар 3.0 сая төгрөг буюу нийт 88.2 сая төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлжээ.

Нэмэлт санхүүжилтээс бичиг хэрэгт 0.5 сая төгрөг, тээвэр шатахуунд 3.6 сая төгрөг, шуудан холбоонд 0.6 сая төгрөг, БҮТЭЗ-д 2.2 сая төгрөг, эм бэлдмэлд 0.9 сая төгрөг, нормын

хувцсанд 2.4 сая төгрөг, багаж техник хэрэгсэлд 7.7 сая төгрөг, урсгал засварт 5.0 сая төгрөг, томилолтын зардалд 0.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 43.8 сая төгрөг, газрын төлбөрт 6.0 сая төгрөг, их засварт 15.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд: Корона вирус - 2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Аудитаар материаллаг буруу тайлагналын болон нөлөө бүхий эрсдэл гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 онд нийт 213.1 сая төгрөгийн 67 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 213.1 сая төгрөгийн 67 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд: Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ын хэрэгжилтийг хянан үзэж хэрэгжилтийг ханган ажилласан байна гэж үзлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын бүртгэл тайлагнал, шилэн дансны мэдээлэлттэй холбоотой 0.3 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн байна. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг дахин шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- Бараа материалын зарлагын гүйлгээг тайлант оны эхнээс сар сараар гаргаж хэвшсэн.
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллээ бүрэн оруулсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөний байдлыг анхаарч үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар үр дүнгийн тайланд бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамж дансаар тайлагнасан 3.2 сая төгрөгийг бусад зардал дансанд залруулж, анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой 5.8 сая төгрөгийн 1 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар үр дүнгийн тайланд 3.2 сая төгрөгийн алдааг засаж залруулав.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой.

1.1. Илрүүлэлт:

Дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтгүйгээр 5.8 сая төгрөгийн түлээ, модны худалдан авалт хийсэн байна. Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4. “доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримттай анхан шатны баримт бүрдүүлж ажиллаж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөвсгөл аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний ТӨВ	2	9.0	1	3.2					1	5.8